



WHITE PAPER

SPCFIN токены танилцуулга

Улаанбаатар 2026



Мэдэгдэл

Энэхүү танилцуулга нь Storepay үйлчилгээний цаашдын бизнесийн замнал, үүнтэй холбоотой Storepay үйлчилгээг олон улсад нэвтрүүлэхэд SPCFIN койн болон SPCFIN токены гүйцэтгэх үүрэг, эдгээрийн хэрэглээний талаар мэдээллийг хүргэх зорилготой юм.

Энэхүү танилцуулга нь SPCFIN криптовалютыг худалдан авах урилга, уриа, гэрээ хийхэд нөлөөлөх зорилгыг агуулаагүй бөгөөд тус танилцуулгыг уншсанаар тус криптовалютыг худалдан авах гэрээний харилцаа үүсэхгүй болно.

SPCFIN койн болон SPCFIN токеныг худалдан авахаас өмнө худалдан авагч холбогдох эрсдэлийг судалж, мэдлэг мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах үүрэгтэй бөгөөд уг танилцуулгын гол зорилго нь сонирхол бүхий этгээдийг шаардлагатай мэдээллээр хангах юм.

Монгол улсын хэмжээнд криптовалют, койн, токен зэргийн асуудлаар гарсан хууль журам, эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал учир худалдан авагчийн хувьд эрсдэл дагуулсан, тодорхой бус нөхцөл үүсэх магадлалтай.

Үүнд: үнэлгээ огцом унах, өсөх, крипто биржүүдийн ажиллагаа доголдох, татварын орчны өөрчлөлт, хууль эрхзүйн зохицуулалтын орчны өөрчлөлт болон бусад урьдчилж таамаглаагүй нөхцөл байдлууд орно

“Стор пэй ББСБ” ХХК-ийн зүгээс Storepay койн (SPCFIN) криптовалютын хоёрдагч зах зээлийн үнэ ханш, тогтвортой, эрсдэлгүй байдлыг хариуцахгүй бөгөөд SPCFIN токены хоёр дагч зах зээлийн үнэ ханш нь чөлөөт зах зээлийн зарчмаар нээлттэй явагдах болохыг анхаарна уу.



Агуулга

- Компанийн тухай
- Монголын санхүүгийн орчин
- BNPL үйлчилгээний тухай
- Тоон үзүүлэлт
- Санхүүгийн тайлангийн хураангуй
- SPCFIN токен
 - SPCFIN ашиглалт ба SPCFIN wallet
 - SPCFIN буцаан олголт буюу Mining Эрэлт ба Нийлүүлэлт
 - Тоо хэмжээ
- Гадаадын зах зээлийн хөгжил
- Бүтэц, баг хамт олон
- Эрсдэлийн менежмент




Компанийн тухай

Storepay & SPCFIN



Компанийн тухай

Storepay нь Монголын хамгийн олон хэрэглэгч, харилцагчтай **Buy Now, Pay Later** буюу **“Одоо аваад, дараа төл”** финтекийн хуваан төлөх шийдлийн үйлчилгээ үзүүлэгч компани юм.






Монголын санхүүгийн орчин

BNPL үйлчилгээ нэвтрэхээс өмнөх Монголын санхүүгийн зах зээл

Банк санхүүгийн байгууллагуудын голлох үйлчилгээ нь зээл, хадгаламж болон лизинг бөгөөд бага үнийн дүнтэй худалдан авалтад зориулсан лизингийн үйлчилгээ ховор, кредит картын үйлчилгээ түгээмэл бус.

2026 оны 1-р улирлын байдлаар Монгол улсад арилжааны



Иргэд зээл, лизинг ашиглан худалдан авалт хийснээр сар бүр хүү, шимтгэлд нь өндөр төлбөр, эцэст нь худалдан авалтын үнийн дүнгээс дунджаар 20-50% илүү мөнгөн дүнг төлөх болдог. Энэ бүхний эцэст оролцогч гурван талын аль алинд ашиггүй нөхцөл байдал үүсдэг:

- Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээг ашиглах хэрэглэгчийн тоо багасч;
- Иргэд хэрэгцээтэй худалдан авалтаа хийж чадахгүй байдал үүсэж;
- Бизнесийн хувьд хэрэгцээтэй бараа, үйлчилгээний борлуулалт хязгаарлагдмал.

Бараа эргэлт, борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд худалдааны салбарынхан маркетингийн үйл ажиллагаанд их хэмжээний зардал гаргах, хямдрал урамшуулал зарлах зэргээр бизнесийн ашигт ажиллагаа багасах гэх мэт зах зээл дээр хоорондоо харилцан холбоотой тодорхой асуудлууд үүсэж байв.



BNPL үйлчилгээний тухай

“Стор Пэй ББСБ” ХХК нь 2019 оны нэгдүгээр сарын 23-ны өдөр иргэд болон бизнесүүдэд тулгараад байсан дээрх асуудлуудыг шийдэх зорилготой үүсгэн байгуулагдсан.

Бид технологийн хөгжил дэвшлийг санхүүгийн цоо шинэ BNPL (Одоо аваад, дараа төл) модельтой нэгтгэн арван сарын турш судалгаа, хөгжүүлэлтийн ажлыг хийж, 2019 оны арван нэгдүгээр сард Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа ямар ч хүү, шимтгэлгүй хуваан төлөх үйлчилгээг нэвтрүүлэв.



Ингэснээр, иргэд ямар нэгэн хүндрэл чирэгдэлгүйгээр 100,000 – 10,000,000 төгрөгийн хооронд Storepay-ийн гэрээт газруудаас ямар нэгэн нэмэлт төлбөргүй, зөвхөн тухайн худалдан авалтын төлбөрийг хуваан төлөх нөхцөлтэйгээр авах боломжтой болов. Энэ нь:

Хэрэглэгчийн хувьд

- Санхүүгийн таатай нөхцөлөөр худалдан авалт хийх
- Хүү, шимтгэлд өндөр төлбөр төлөхгүй байх
- Цалин, орлогод уялдуулан санхүүгээ төлөвлөх


Харилцагч байгууллагын хувьд

- Илүү олон худалдан авагчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэх
- Борлуулалтын шинэ бөгөөд хялбар сонголтыг үйлчлүүлэгчдэд санал болгох
- Худалдааны бодит эргэлт, өсөлтөө нэмэх
- Хамтарсан маркетинг хийж, брэндийн танигдалт борлуулалтыг нэмэх зэрэг давуу талуудыг өгсөөр байна



BNPL үйлчилгээний тухай

Стор пэй бүтээгдэхүүний төрөл болон борлуулалтын эзлэх хувь



2026 оны 5 сарын 22-ны өдрийн байдлаар



Тоогоор

Storepay & SPCFIN



Storepay / Тоогоор

Тоон үзүүлэлт

16 тэрбум ₮

Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын орлого

8,413

Сторпэй үйлчилгээ
боломжтой дэлгүүр,
үйлчилгээний төв

631,921

Бүртгэлтэй
хэрэглэгчид

15%+

Сторпэй үйлчилгээ
нэвтрүүлснээр мерчантад бий
болсон борлуулалтын өсөлт

4,312,271

Нийт хийгдсэн худалдан
авалтын тоо

1,562.8+
тэрбум ₮

Нийт худалдан авалтын
дүн

140.6+
Тэрбум


Хэрэглэгчдэд үүсгэсэн
хэмнэлт

2026 оны 5 сарын 22-ны өдрийн байдлаар




Storepay / Тоогоор


Тоон үзүүлэлт
(Өссөн дүнгээр)



Storepay
Борлуулалт



Storepay
Бүртгэлтэй хэрэглэгч



Storepay
Боломжтой салбар, дэлгүүрүүд

2026 оны 5 сарын 22-ны өдрийн байдлаар



АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2025.12.31	2024.12.31
Хүү болон түүнтэй адилтгах орлого	268.66	355.95
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(456.44)	(8.47)
Цэвэр хүүгийн орлого	(187.78)	347.48
Шимтгэл, хураамжийн орлого	41,248.52	24,961.36
Шимтгэл, хураамжийн зардал	(730.44)	(217.51)
Цэвэр шимтгэл, хураамжийн орлого	40,518.09	24,743.86
Эрсдэлийн сангийн зардал	(8,436.31)	(877.15)
Үнэ цэнийн бууралтын дараах цэвэр орлого	31,894.00	24,214.18
Ерөнхий ба удирдлагын зардал	(11,908.71)	(7,935.79)
Бусад орлого	13,081.86	4,805.54
Бусад зардал	(2,046.49)	(10,785.74)
Бусад олз/ (гарз)	(4,303.75)	1,167.55
Татварын өмнөх ашиг	26,716.90	11,465.74
Орлогын татварын зардал	(6,537.19)	(2,226.64)
Тайлант жилийн ашиг	20,179.71	9,239.10
Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний олз	2,622.74	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого	22,802.46	9,239.10



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН (сая төгрөгөөр)

Хөрөнгө	2025.12.31	2024.12.31
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	2,143.99	1,055.48
Биет бус хөрөнгө	5,675.66	554.95
Ашиглах эрхтэй хөрөнгө	1,186.98	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,039.68	252.69
Хөрөнгө оруулалт	501.00	501.00
Нийт эргэлтийн бус хөрөнгө	11,547.31	2,364.12
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	16,162.26	3,991.61
Харилцагчид олгосон зээл - цэвэр	1,089.17	-
Факторингийн авлага	58,095.95	35,597.43
Бусад авлага	4,895.12	3,737.60
Бусад санхүүгийн бус хөрөнгө	767.81	994.27
Нийт эргэлтийн хөрөнгө	81,010.31	44,320.91
Нийт хөрөнгө	92,557.62	46,785.03

Хөрөнгө	2025.12.31	2024.12.31
Өр төлбөр		
Бондын өр төлбөр	8,032.41	-
Бусад санхүүгийн өр төлбөр	32,123.28	15,809.70
Бусад санхүүгийн бус өр төлбөр	3,627.26	3,344.49
Түрээсийн өр төлбөр	841.37	-
Нийт өр төлбөр	44,624.32	19,154.19
Эздийн өмч		
Хувь нийлүүлсэн капитал	2,785.89	2,785.89
Эздийн өмчийн бусад хэсэг	2,622.74	-
Хуримтлагдсан ашиг	42,524.66	24,844.95
Нийт эздийн өмч	47,933.29	27,630.84
Нийт өр төлбөр болон эздийн өмч	92,557.62	46,785.03



Аудитын дүгнэлт – 2025 он



Нexia Глобал Монголиа Аудит ХХК
Зuйилэн Уул Бoлoмч, 010 тoтo, 6-р дaвхар
Уулсaнбaр, Мoнгол Улс
Утас: +976 1700 1503
Вeб зaл: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

“СТОР ПЭЙ БЭСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Аудиторын дүгнэлт

Бид “Стор Пэй БЭСБ” ХХК (дараахд “Компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон үеийн жилийн дэлгэрэнгүй оролтын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйцээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйцээж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББДУСЗ”)–өөс гаргасан Санхүүгийн тайлагчлын олон улсын стандартууд (“СТОУС”)–ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)–уудын дагуу хийж гүйцэтгэв. Үг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлагчийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын өс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэцсэн нягтлан бодогчдын өс зүйн дүрэм”-ийн дагуу Компанаас хэсвэл бус бөгөөд уг дүрэмд эвсэсэн дагуу өөрсдийн бусад өс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотлоогоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохиистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор удирдлагын хүтээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС–ын дагуу бэлтгэх, үнэн зөв тогилуулах ба заллах, алданы улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлосон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээв.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахад удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлж, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн тайлагчлын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг

Залилан эсвэл алданаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ анхдаг зах талнаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохиистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”–ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлж гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алданаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь ажлаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлж магадлалтай бол материаллаг тооцогдоно.

НEXIA ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Нexia Илэрхийлэлчлэлийн албан ёсон, бие даасан гишүүн
Вeб: www.nexia.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн тайлантай холбоотойгоор аудиторын хүлээх үүрэг (үргэлжлэл)

АОУС–ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алданы улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохиромжтой аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болгохыг хангалттай, зохиистой аудитын нотлоогоор олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар эргийлүүлэх, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зарчих зарга үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагчлыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алданаас үүдэн гарсан буруу тайлагчлыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүнхэлт өгөх зорилгоор биеш тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горим боловсруулахын тулд аудитад хамраалттай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Харгалсан нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохиистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойлголцоосон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохиистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотлоогонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадмагид мэдэгдэхүйц эргэлзэж үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүнхэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотлоогонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үндэ тодруулгууд багтана)–ын ерөнхий тогилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв тогилуулгын шаардлагыг хангахгүй байдалаар холбогдох ажил гүйцэтгэж, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан агуулгуудыг Компанийн удирдлагад мэдэгддэг.

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор бус, Монгол Улсын “Компанийн тухай хууль”–ийн 94 дүгээр зүйлд зөвсөн дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмч хариуцлага хүлээхгүй болно.

НEXIA ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Мэргэцсэн нягтлан бодогчид



Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2028 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

НEXIA ГЛОБАЛ МОНГОЛИА АУДИТ ХХК
Нexia Илэрхийлэлчлэлийн албан ёсон, бие даасан гишүүн
Вeб: www.nexia.com



SPCFIN TOKEN

Storepay & SPCFIN



SPCFIN токен



Storepay нь өөрсдийн дэд бүтцэд тулгуурлан “SPC” (Storepay Coin) шинэ криптовалютыг Монголын зах зээлд анхлан танилцуулсан.

“Стор пэй” ББСБ ХХК нь өөрийн дэд бүтцэд тулгуурлан “SPC” (Storepay coin) криптовалютыг 2021 онд Монголын зах зээлд анхлан танилцуулж, 18.0 тэрбум төгрөг босгосон. Компани IEO хийж, татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотой холбогдох татвар, хураамжийг хууль журмын дагуу тайлагнан, улсын төсөвт төвлөрүүлсэн болно.

SPC нь Binance Smart Chain-д суурилсан BEP20 стандартын токен бөгөөд Монгол болон Азийн хэрэглэгчдэд блокчейнд суурилсан худалдан авалтын урамшууллын ухаалаг ба өгөөжтэй шийдлийг санал болгож байна.

Бид storepay үндсэн үйлчилгээний эрх үүсгэх, нэмэгдүүлэх, худалдан авалтын төлбөрийн эргэн төлөлтөнд ашиглах, худалдан авалтын урамшуулал буюу буцаан олголт, staking үйлчилгээний урамшуулал зэргээр SPC-ийн цогц экосистемийг бий болгохоор төлөвлөж, зөвхөн Монголын зах зээлээр хязгаарлагдахгүй цар хүрээгээ тэлэхээр ажиллаж байна.

Компани 2025 оны 2-р улиралд брэндингийн шинэчлэл хийсний үндсэн дээр SPC токены нэр, лого шинэчлэгдэж SPCFIN нэртэй болсон.



SPCFIN токен

Блокчейн технологи нь

Орон зайд
хязгаарлагддаггүй буюу
бодит утгаараа глобал

Хэрэглэхэд хялбар
ба маш хурдан

Мэдээлэл
солилцоо
ил тод

Өндөр зэрэглэлийн
буюу криптограф
хамгаалалттай


Тэгвэл криптовалютын хувьд иргэдийн дунд гардаг гол шүүмжлэлүүд нь хэрэглээгүй, зөвхөн “speculative” арилжааны хэрэгсэл буюу ханшийн өсөлт, уналт дээр мөрийцөн ашиг хүртэх, алдагдал хүлээх боломжийг дагуулсан хэрэгсэл гэсэн ойлголт түгээмэл бий.

Үүний гол шалтгаан нь ихэнх токеныг гаргаж байгаа бизнесүүд нь шинээр гарч байгаа стартапууд бөгөөд өөрсдийн санааг бодит болгох хөрөнгийг босгох зорилготой гарч байгаа нь эрсдэлийг дагуулдаг.



SPCFIN токен

SPCFIN дараах давуу талуудтай:



SPCFIN нь Storepay үндсэн үйлчилгээнд ашиглагдаж эхэлснээр урамшуулал буцаан олголтыг илүү боловсронгуй болгох өдөр тутамд ашиглагдах боломжтой зах зээлийн эргэлтэд шууд орох бололцоо бүхий шинэ төрлийн цахим хөрөнгө болсон.

Бизнесийн хувьд SPCFIN нь Storepay-ийн Зүүн Өмнөд Азийн зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээгээ нэвтрүүлэх төлөвлөгөөний суурь болж байгаа бөгөөд Монгол болон бусад Storepay үйлчилгээ нэвтэрсэн зах зээлүүдэд нэгдмэл байдлаар хил хязгаар орон зайг хамаарахгүйгээр ашиглагдах боломжтой санхүүгийн бодит хэрэглээтэй бүтээгдэхүүн болгон хөгжүүлээ.




SPCFIN токен

SPCFIN ашиглалт ба SPCFIN wallet

SPCFIN нь Storepay үйлчилгээний 600,000 хэрэглэгчдийн, +8,000 гэрээт байгууллагуудаас хийгдэж буй худалдан авалтад, мөн худалдан авалтын буцаан олголт, цоо шинэ үйлчилгээ болох SPCFIN wallet үйлчилгээнүүдэд ашиглагдаж байна.

SPCFIN Wallet-ын онцлох функцууд:






SPCFIN токен


SPCFIN mining & SPCFIN burn

0.5%



SPCFIN
mining

1%



SPCFIN
burn

Хэрэглэгчдийн хувьд Storepay үйлчилгээг ашиглан хийсэн худалдан авалтаа хугацаандаа төлж дуусах бүртээ үнийн дүнгийн 1%-тай тэнцэх хэмжээний SPCFIN буцаан олголт авах боломжтой байсан бол 2023 оны 02 дугаар сараас эхлэн буцаан олголтын SPCFIN-г 0.5% болгон бууруулж, худалдан авалтанд олгосон урамшууллын SPCFIN-г 2 дахин нэмэгдүүлсэн дүнгээр буюу худалдан авалтын үнийн дүнгийн 1%-тай тэнцэх үнийн дүн бүхий SPCFIN-г хоёрдогч зах зээлээс компани худалдан авч шатааж байна. Ингэснээр зах зээл дээрх SPCFIN токены тоо хэмжээ 14 хоног тутамд тодорхой дүнгээр хорогдож байгаа юм.



SPCFIN токен

Эрэлт

SPCFIN нь дотоод болон гадаадын криптовалютын биржүүдэд хөрөнгө оруулалтын хэрэгслээр ашиглагдахаас гадна Storepay үндсэн үйлчилгээнд ашиглах, худалдан авалтын буцаан олголт зэрэг хэлбэрээр зах зээлийн эрэлт, нийлүүлэлт нь хангагдаж явах бөгөөд ингэснээр SPCFIN-ийн тогтмол “хэрэглээтэй” байдал нь хангагдаж, тогтмол гүйлгээнд байна.

SPCFIN токены эрэлт Storepay хэрэглэгчдийн тоог даган шууд хамааралтай байдлаар нэмэгдэж байгаа бөгөөд SPCFIN токены IEO (Initial Exchange Offering) хийгдсэнээс хойш хэрэглэгчид SPCFIN токеныг Монголд үйл ажиллагаа явуулж буй крипто биржүүдээс худалдан авч Storepay үйлчилгээнд ашиглаж байна.

Storepay үйлчилгээ нь зах зээлд аль хэдийнээ нэвтэрсэн байнгын худалдан авалт, тогтмол идэвхтэй хэрэглэгчийн баазтай тул хэрэглээнд шууд нэвтэрсэн ба Storepay апп дээрх үндсэн үйлчилгээнд ашиглагдах эрэлт үүсгэх давуу талтай байна.

Цаашлаад Зүүн өмнөд Азийн 676 сая хэрэглэгчтэй зах зээлд Storepay үйлчилгээг нэвтрүүлж, SPCFIN-г олон улсын төвлөрсөн бус (decentralized- DEX) болон төвлөрсөн (centralized – CEX) биржүүд дээр гаргаснаар SPCFIN-ийн эрэлт, хэрэглээ нэмэгдэх боломжтой.



SPCFIN токен

Нийлүүлэлт



SPCFiN
Storepay Fintech

SPCFIN токены IEO-д нийт токены 15% буюу 90 тэрбум SPCFIN токен Монгол улсын зах зээлд гарсан бөгөөд энэхүү нийлүүлэлт нь цаашдын Storepay үйлчилгээнд ашиглагдах токены эрэлтийг хангаж ажиллана.

Storepay худалдан авалтад хэрэглэгч төлбөрөө хугацаандаа төлж дуусах үед үнийн дүнгийн 0,5%-д SPCFIN токен буцаан олголт олгогдох бөгөөд буцаан олголт, урамшуулалд олгогдох SPCFIN токен нь урамшууллын пүүлээс олгогдож байна. Урамшууллын пүүлээс токен олгогдож байна гэдэг нь эргээд Storepay үйлчилгээний эрэлт хэрэгцээ зах зээлд нэмэгдэж, өргөжин тэлж байгаагийн илрэл бөгөөд шууд хамаарлын зарчмаар SPCFIN токены эрэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болох юм.





Нийлүүлэлт

SPCFIN IEO

Койны нэр:	StorePay Coin
Тикер:	SPCFIN
Blockchain:	Binance Smart Chain
Address:	BEP20
Нийт нийлүүлэлт:	600,000,000,000
IEO нийлүүлэлт:	90,000,000,000
IEO үнэлгээ:	0.20₮
IEO татан төвлөрүүлэлт:	18,000,000,000₮
IEO эхлэх хугацаа:	2021.10.27 11:00
IEO дуусах хугацаа:	2021.10.29 17:00
IEO явагдах бирж:	trade.mn
Нэг хүний лимит:	15,000,000₮

SPCFIN койны анхны хуваарилалт

Нийт нийлүүлэлт:	600,000,000,000 / 100%
IEO:	90,000,000,000 / 15%
Хоёрдогч зах зээлд:	60,000,000,000 / 10%
Storepay Holding Singapore:	180,000,000,000 / 30%
Хөрвөх чадвар:	60,000,000,000 / 10%
Олон улсын стратегийн түншлэл:	66,000,000,000 / 11%
Урамшуулал, идэвхжүүлэлтийн сан:	54,000,000,000 / 9%
Үүсгэн байгуулагчид, баг бүрэлдэхүүн, зөвлөх:	30,000,000,000 / 5% (Locked for 1 year)
Стратегийн нөөц:	60,000,000,000 / 10%

Storepay Coin

Дахин хэвлэгдэх боломжгүй, шатаах боломжтойгоор үүсгэгдсэн.



SPCFIN токен загвар

SPCFIN токены тоо хэмжээ (2026.05.22-ны өдрийн байдлаар)



SPCFIN 62,892,106,891

Нийт SPCFIN токен

SPCFIN 34,730,916,912

2022.01.01 – 2026.05.22 хооронд
урамшуулалд олгосон дүнгээс
шатаасан SPCFIN токен

SPCFIN 376,875,196

SPCFIN staking үйлчилгээний
урамшуулалд олгосон

SPCFIN 502,000,100,001

Удирдлагын шийдвэрээр бусад
сангаас шатаасан



Гадаадын зах зээлийн хөгжил

Storepay & SPCFIN



Гадаадын зах зээлийн хөгжил





Зүүн Өмнөд Азийн зах зээлийн тэлэлт

Блокчейн технологи, крипто хөрөнгийн давуу талууд болох хил хязгаар, газар нутаг, орон зайг үл хамааран ашиглагдах боломж нь бидэнд энэхүү нэвтрүүлэлтийн ажлыг хийх гол хүчин зүйл нь болж байгаа бөгөөд **Storepay үйлчилгээ нэвтэрсэн бүхий л зах зээлд SPCFIN койн нь нэгдмэл байдлаар ашиглагдан зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлсэн олон улс хоорондын экосистем бүрдүүлэх боломжийг нээж байна.**

SPCFIN койн нь Storepay үйлчилгээ нэвтэрсэн улсуудын дотоодын крипто биржүүд болон олон улсын крипто биржүүдэд арилжаалагдах бөгөөд аль ч улс орны хэрэглэгч ашиглах, хоорондоо арилжаалах боломжийг бүрдүүлэх юм.



Бүтэц Баг хамт олон

Storepay & SPCFIN



Бүтэц, баг хамт олон

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

“Стор пэй ББСБ” ХХК нь Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч нь Бүгд Найрамдах Сингапур Улсад бүртгэгдсэн Storepay Holding Pte.Ltd бөгөөд тус компани нь компанийн хувьцааг 100% эзэмшиж байна.


2025 оны 6-р сарын байдлаар токен гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц дараах байдалтай байна.





Бүтэц, баг хамт олон

Стор пэй ББСБ ХХК-ийн бүтэц



Бүтэц, баг хамт олон

Storepay Holding Pte.Ltd ТУЗ-ийн гишүүд



ТУЗ-ийн дарга
Гиллес Гүерриер де Думаст

Crédit Agricole CIB, Deutsche Bank, Credit Suisse First Boston, Bankers Trust, JP Morgan зэрэг дэлхийн тэргүүлэх санхүүгийн байгууллагуудад 35 гаруй жил хөрөнгө оруулалтын банкны салбарт ажилласан туршлагатай. Amundi Group-ийн Гүйцэтгэх захирлын ахлах зөвлөхөөр ажиллаж, Amundi South Asia болон Amundi North Asia-ийн хяналтын зөвлөлийг үүсгэн байгуулсан. Францын Sciences Po Paris их сургуулийн санхүүгийн магистр зэрэгтэй.



ТУЗ-ийн гишүүн
Н.Хангал

Бизнесийн салбарт 15 гаруй жилийн туршлагатай, инновацлаг бизнесүүдийг үүсгэн байгуулж, хөгжүүлсэн бизнес эрхлэгч. Спортын чиглэлийн "Sole" сэтгүүл болон Mobile Advertising LLC зэрэг төслүүдийг үүсгэн байгуулсан туршлагатай. Австралийн Квинсленд Технологийн Их Сургууль (Queensland University of Technology)-д магистрын зэрэг хамгаалсан.



ТУЗ-ийн гишүүн
Алберт Момджян

UBS AG, HSBC, Credit Suisse, Merrill Lynch, Crédit Agricole-CIB зэрэг дэлхийн тэргүүлэх санхүүгийн байгууллагуудад 25 гаруй жил ажилласан туршлагатай хөрөнгө оруулалтын банкны мэргэжилтэн. Олон улсын санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр гүнзгий мэдлэг, арвин туршлагатай. Францын University of Paris Dauphine их сургуульд олон улсын санхүүгийн магистрын зэрэг хамгаалсан.



ТУЗ-ийн нарийн бичиг
Сесилия Баррадад

Хөрөнгө оруулалтын шинжилгээ, төслийн хэрэгжилт болон тогтвортой хөгжлийн санаачилгуудыг хэрэгжүүлэх чиглэлээр 13 гаруй жилийн туршлагатай. Тэрээр Хойд Ази, Зүүн Өмнөд Ази, Африк болон Латин Америкт олон улсын төслүүд дээр ажиллаж байсан. Sciences Po Paris болон London School of Economics-оос магистрын зэрэгтэй. Мөн Тогтвортой санхүү, Дугуй эдийн засаг ба тогтвортой хөгжлийн стратеги (Cambridge), Байгаль орчны хамгаалал ба тогтвортой хөгжил, Төслийн удирдлага, Дата шинжлэх ухаан (Harvard) чиглэлээр мэргэжлийн сертификатууд эзэмшсэн.



ТУЗ-ийн гишүүн
Ману Бхаскаран

Вашингтон хотод төвтэй Centennial Group-ийн түнш бөгөөд Сингапур дахь Centennial Asia Advisors компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал. Азийн улс төр, эдийн засгийн шинжилгээний чиглэлээр 40 гаруй жилийн туршлагатай мэргэжилтэн. Өмнө нь Société Générale банкны Азийн хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаанд удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд Сингапурын Засгийн газарт бодлого, эдийн засгийн шинжилгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Мөн үндэсний зохицуулалтын байгууллагууд болон олон улсын компаниудын ТУЗ-д гишүүнээр ажиллаж байсан. Кембрижийн их сургууль болон Harvard Kennedy сургуульд боловсрол эзэмшсэн бөгөөд Chartered Financial Analyst (CFA) мэргэжлийн зэрэгтэй.



ТУЗ-ийн гишүүн
Ц.Мэндбаяр

Монголын технологийн салбарын тэргүүлэх компаниудын нэг болох Intelmind LLC-ийн хамтран үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал. 2017 оноос хойш Монголын дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжин ажиллаж, онлайн худалдааны хэрэглээ, нэвтрэлтийг өргөжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан. Түүний удирдлага дор Shoppymn, Cody, JoinMe, Coinhub зэрэг дижитал платформууд амжилттай хөгжиж, Монголын цахим худалдаа, технологийн экосистемийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн Euro Chamber Mongolia-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд Shoppu Hub платформуор дамжуулан Alibaba-ийн 1688 платформтой стратегийн түншлэлийг амжилттай байгуулсан.



ТУЗ-ийн гишүүн
Жастин Г. Күүпер

Foxcroft Strategy Group LLC-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал. Байгууллагууд болон удирдах түвшний шийдвэр гаргагчдад компанийн стратеги, нэр хүндийн менежмент, бизнес болон бодлогын нарийн төвөгтэй орчинд стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. АНУ-ын Ерөнхийлөгч асан Билл Клинтоны урт хугацааны зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд дэлхийн улс төр, бизнесийн удирдагчид, Fortune 50 компанийн гүйцэтгэх удирдлагууд болон олон улсын томоохон санаачилгуудад стратегийн зөвлөгөө өгч ажилласан туршлагатай. Мөн Цагаан ордонд (White House) Ерөнхийлөгчийн Тамгын газрын туслхаар ажиллаж байсан. Fortham Law School-ийн хууль зүйн доктор (J.D.), American University-ээс бакалаврын зэрэгтэй. Odoogoor American University in Dubai-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж, олон улсын хэд хэдэн байгууллагын ТУЗ-д гишүүнээр ажиллаж байна.

Бүтэц, баг хамт олон

Стор пэй ББСБ ХХК менежментийн баг



Үүсгэн байгуулагч & Гүйцэтгэх захирал
Н.Хангал

Бизнесийн салбарт 15 гаруй жилийн туршлагатай, инновацлаг бизнесүүдийг үүсгэн байгуулж, хөгжүүлсэн бизнес эрхлэгч. Спортын чиглэлийн "Sole" сэтгүүл болон Mobile Advertising LLC зэрэг төслүүдийг үүсгэн байгуулсан туршлагатай. Австралийн Квинсленд Технологийн Их Сургууль (Queensland University of Technology)-д магистрын зэрэг хамгаалсан.



Санхүү эрхэлсэн захирал
Б.Цэнгэл

Эрсдэлийн удирдлага, санхүүгийн удирдлага болон корпорацийн санхүүгийн чиглэлээр 10 гаруй жилийн туршлагатай. Хаан Банк болон Говь ХК-д ажиллаж байх хугацаандаа олон улсын онлайн бизнесийн тэлэлт, санхүүгийн үйл ажиллагаанд төвлөрөн ажилласан. Австралийн University of New South Wales их сургуульд санхүүгийн магистрын зэрэгтэй бөгөөд CFA (Chartered Financial Analyst) Level III кандидат юм.



Үйл ажиллагаа эрхэлсэн захирал
Э.Баярмаа

Газрын харилцааны салбарт 11 жил ажилласан туршлагатай. Тэрээр Мянганы сорилтын сангийн Хөрөнгийн эрхийн төсөлд Газрын зах зээлийн мэргэжилтэнгээр ажлын гараагаа эхэлсэн ба ШУТИС-д Газар зохион байгуулалт чиглэлээр багшилж байсан. Тэрээр 2023 оны 6 дугаар сараас "Стор пэй ББСБ" ХХК-ийн багт нэгдэн ажиллаж байна.



Гадаад түншлэл, хамтын ажиллагаа
Г.Цацал

SaaS, Fintech болон Blockchain салбарт 9 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр SaaS үйлчилгээ үзүүлэгч AND Solutions компанид бизнес хөгжлийн чиглэлээр Зүүн Өмнөд Азийн зах зээл дээр төвлөрөн ажиллаж байсан. Мөн Дани улсын Nordic Blockchain Association-д үйл ажиллагаанд оролцож байсан туршлагатай. Данийн Copenhagen Business School-оос магистрын зэрэг (MSc) хамгаалсан.



Ерөнхий нягтлан бодогч
Ж.Болортуяа

Санхүү, хөрөнгийн зах зээлийн салбарт +15 жил ажилласан туршлагатай. 2008 онд Мосдак ХХК-д Нягтлан бодогч, төслийн мэргэжилтэнгээр ажлын гараагаа эхэлж, Монголын хөдөө аж ахуйн бирж, Монголын эрдэс баялгийн биржүүдийн төслийн ТЭЗҮ боловсруулах багуудад ажиллаж байсан. СЭЗДС-ийг Нягтлан бодогч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсөж, 2016 онд Мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхийн гэрчилгээ авсан.



Систем хөгжүүлэлтийн
чиглэлээр хамтран
ажиллагч

Текпорт ХХК нь 2023 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд мэдээллийн технологи, программ хангамжийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш харилцагчдынхаа өдөр тутмын хэрэгцээ, шаардлагад нийцсэн, дэвшилтэт технологид суурилсан шийдлүүдийг амжилттай хөгжүүлэн нэвтрүүлсээр байна.

Тэдний анхны томоохон бүтээгдэхүүн болох “Etsalin” аппликейшн нь хэрэглэгчдэд цалин буухыг хүлээлгүй, хүссэн цагтаа, хүссэн газраасаа ямар ч хүү, шимтгэлгүйгээр цалингийн урьдчилгаа авах боломжийг олгодог.

Текпорт ХХК нь 2024 онд “Стор пэй ББСБ” ХХК-ийн охин компани болсноор үйл ажиллагаагаа улам өргөжүүлж, хөгжлийнхөө шинэ шатанд гарсан. Уг компани нь “Storepay 4.0” хувилбарыг амжилттай хөгжүүлэн, хэрэглэгчдэдээ хүргэн ажиллаж байна.



Эрсдэлийн менежмент

“Стор пэй ББСБ” ХХК нь эрсдэлийн удирдлага, хяналтын зохистой засаглалын тогтолцоог Хамгаалалтын 3 бүсийн зарчимд тулгуурлан олон улсын эрсдэлийн менежментийн стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх, учирч болох эрсдэлээс сэргийлэх, бууруулах зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлого, журмуудыг боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөхөөс гадна эрсдэлийг зохистой түвшинд удирдахыг зорин ажиллаж байна.

Компанийн үйл ажиллагаанд учирч болох дараах гол эрсдэлүүд байх боломжтой бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй.

Хууль тогтоомж, зохицуулалтын өөрчлөлт:

Виртуал хөрөнгө гаргагчийн болон үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, зохицуулалтын баримт бичгүүдэд томоохон өөрчлөлт оруулах тохиолдолд SPCFIN-ийн ханшийн хэлбэлзэл үүсгэж болзошгүй.

Нэр хүндийн эрсдэл:

Компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл байдал, нийгмийн цахим сүлжээний сөрөг хандлагаас үүсэх боломжтой бөгөөд SPCFIN-ийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх, ханшийн хэлбэлзэл үүсгэх боломжтой. Эрсдэлийг бууруулахын тулд бид компанийн үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг ханган, тогтмол сайжруулалт хийж, бүхий л хууль журмыг мөрдөн ажиллаж байна.

Зах зээлийн ханшийн хэлбэлзэл:

SPCFIN-ийн үнэ цэн, зах зээлийн ханш нь зах зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан хэлбэлзэх боломжтой бөгөөд үүнд токен гаргагч нөлөөлөх боломжгүй.

Эдийн засгийн өөрчлөлт:

Макро эдийн засгийн нөхцөл байдал, валютын ханшийн өөрчлөлт, хэрэглэгчийн эрэлт, өрсөлдөгчийн үйл ажиллагаа зэргээс хамааран компанийн үйл ажиллагаа доголдох, санхүүгийн алдагдалд орох, зах зээлд эзлэх хувь хэмжээ буурч ханшийн хэлбэлзэл үүсч болзошгүй.

Гадаад хүчин зүйлс:

Хэрэглэгчийн санаатай болон санамсаргүй үйлдлээс хамааран хувийн мэдээллээ алдах, аливаа гэмт хэргийн шинжтэй халдлагад өртөх, бирж, гуравдагч этгээдийн үйл ажиллагаатай холбоотойгоор SPCFIN-ийн ханшийн хэлбэлзэл, алдагдал үүсэх боломжтой.

Мэдээллийн аюулгүй байдал:

Мэдээллийн системийн доголдолтой байдлаас болж хэрэглэгчийн нууцлалтай мэдээлэл алдагдаж болзошгүй эрсдэл. Энэхүү эрсдэлээс сэргийлэхийн тулд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд МАБУТ-ны ISO 27001:2022 стандартыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Системийн найдвартай ажиллагаа:

Системийн хэвийн үйл ажиллагаа тасалдаж болзошгүй эрсдэлийг бууруулахын тулд зорилтот хүчин чадлын хязгаарын дотор аппликейшнийн ачаалал даах чадварыг тестлэх, холбогдох сайжруулалт, өргөтгөлийн ажлуудыг тогтмол хийж байна.

Даатгагдахгүй:

SPCFIN нь Монгол улс болон Олон улсын даатгалын компанид хөрөнгө оруулагчдыг хамгаалах даатгалд хамрагддаггүй.

Хууль ёсны байдал:

SPCFIN нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аливаа төрлийн үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл, төлбөрийн хэрэгсэлд тооцогдохгүй.



Storepay албан ёсны хуудсууд



Виртуал хөрөнгөнд хийсэн технологийн аудитын дүгнэлттэй танилцах:

CertiK Audit:

<https://skynet.certik.com/projects/storepay-fintech>



View BscScan:

<https://bscscan.com/token/0x16f0d99be1fbD0312641E318c53A63B40AAF5df6>



Хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж, Эн Эм тауэр, 20 давхар



Утас:

7611-0111



И-Мэйл:

info@storepay.mn



Вэбсайт:

<https://storepay.global>



Telegram:

<https://t.me/storepayspc> (гадаад)

<https://t.me/+LuOALRFR6Yo5MDY9> (дотоод)



Facebook:

<https://www.facebook.com/storepay.mn>



Instagram:

<https://www.instagram.com/storepay.mn/>



Medium:

<https://storepayspcfin.medium.com/>



Twitter:

https://twitter.com/Storepay_SPCFIN



Анхаарал хандуулсанд баярлалаа

Улаанбаатар 2026